

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 08/293

НШУС

2008

«СОНИН» ГЭДЭГ ҮГИЙН УЧИР

Л.Норовсүрэн*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн профессор

Түлхүүр үг: өдөр тутмын, хэвлэлийн бүтээгдэхүүн, том хуудас, ордны сонин, сонинсайхан, бичиг товхимол, унаган үг, мэнд усаа мэдэлцэх, зан заншил.

Mанай орны хэвлэлийн салбарт дэвшилтэй шинэ технологи эрчимтэй нэвтэрсний ачаар өнөөгийн сонин хэвлэлийн хийц хэлбэр, өнгө төрх эрс сайжирсныг хүн бүхэн мэднэ. Нийгэм-улс төрийн ардчилсан тогтолцоонд шилжсэнтэй уялдан хэвлэл мэдээллийн үүрэг, зарчим үндсээрээ өөрчлөгдөж, нийтлэлийн сэдэв, агуулгад эргэлтийн шинжтэй өөрчлөлт гарсныг ч хүлээн зөвшөөрөхгүй байх аргагүй. Гэвч “сайны хажуугаар саар” гэгчээр сонин хэвлэлийн үйл ажиллагаанд сүүдэртэй юм байсаар байгаа нь хэн бүхэнд илэрхий билээ. Энэ өгүүллийг бичих болсон шалтгаан ч үүнтэй холбоотой юм.

Дэлхийн улс орнуудад сониниг үүсгэх хэрэгцээ шаардлага ерөнхийдөө нийтлэг шинжтэй байсан боловч түүний

нэрийтгэл нэрийн утга адилгүй байдаг. «Сонин» гэдэг үг анх латины «өдрийн» гэсэн утгатай «Diurnalem» гэдэг үгнээс гаралтай гэж үздэг.

Энэ үг XII зууны үед франц хэлэнд орохдоо «Journal»-«Өдөр бүрийнх» болжээ. О.Блок, Вон Вартбург нарын Франц үгийн гарал үүслийн тайлбар тольд уг үгийн гарлыг сонгодог латин хэлний «Diurnus» буюу мөн л «Өдрийн» гэсэн үгнээс үүсэлтэй гэсэн байна. Тэд уг үгийг «Өдөр тутмын сонини хэлбэртэй роман», «Бүртгэлийн дэвтэр», «Зурагт сонин», «Загварын сэтгүүл», «Хүүхдийн ном», «Ном хэвлэл дэх хүүхдэд зориулсан булан», «Цаг үеийн мэдээлэл» гэх мэт олон утгатай гэж тайлбарлажээ. Италид ч гэсэн сониниг «Diurnus»-«Өдрийн» гэсэн үгнээс гаралтай гэдэг. Түүнчилэн англи хэлний «Newspaper»-ийг ч бас «Өдөр тутам, долоо хоног бүр гардаг гол өгүүллээс гадна шинэ мэдээ, баримттай зүйл, зар нийтэлдэг хэвлэл» гэж тайлбарласан байна. Мөн Пауль Робертын Франц хэлний тольд

«Journal»-ийг «Өдөр бүрийнх» гэсэн утгатай гэсэн бол, харин «Revue» буюу «Сэтгүүл»-ийг «Дахин харах», «Үзлэг», «Тойм» гэх мэт утгатай гэжээ.

Харин Германд арай өөр бөгөөд, тэд сониныг «Zeitung» гэх бөгөөд «Чухал үйл явдлын мэдээлэл, реклам нийтэлдэг олон нутгисан том хуудас бүхий хэвлэлийн бүтээгдэхүүн» хэмээн тайлбарлажээ. Ялгаа нь «Өдрийн», «Өдөр бүрийнх» гэсэн санаа энд алга. Эдгээрээс үзвэл «Journal» нь бидний ярьж заншсанаар сэтгүүл биш, харин сонин гэсэн утгыг илэрхийлдэг байна. Учир нь өдөр бүр гардаг хэвлэгдэхүүн бол сэтгүүл биш, харин сонин байх ёстой. Бидний дээр дурдсан «Revue» гэдэг уг ч үүнийг давхар нотолно. Дахин давтан анхааралтай үзэж харах, үзлэг шинжилгээ бүхий, бас удаан хугацааны үйл явдлыг тоймлон нэгтгэсэн хэвлэлийн бүтээгдэхүүн бол яав ч сэтгүүл байх ёстой.

Сонин хэмээх мэдээллийн хэрэгсэл анх хэзээ, хаана бодитой үүссэн бэ? гэдэг асуултын хариу тийм ч тодорхой бус юм. Европ дахинь сонинуудын эх суурь Итали оронд тавигдсан гэж үздэг. Италийн Венеци хот эрт үеэс олон улсын усан замын боомт, худалдаа

наймааны их хөлийн газар байжээ. Венецийн худалдааны ордон хотод өдөр бүр ирж, буцдаг усан онгоцны цагийн хуваарь, тийзийн үнэ, банкны болон бараа таваарын ханшны өөрчлөлт, элдэв зар зэргийг мэдээлэх тусгай хуудас гаргадаг байв. Тэр хуудсыг Италийн «Gazzetta» хэмээх бутархай мөнгөөр худалдан авдаг байжээ. Яваандадаа уг мэдээллийн хуудас нь түүнийг худалдан авдаг бутархай мөнгө «Gazzetta»-ын нэрээр нэрлэгдэх болсон байна. Тэр нэр Европын зарим орноор тарж, улмаар Орост сониныг «Газета» гэх болжээ.

Венецийн худалдааны ордон хотод өдөр бүр ирж, буцдаг усан онгоцны цагийн хуваарь, тийзийн үнэ, банкны болон бараа таваарын ханшны өөрчлөлт, элдэв зар зэргийг мэдээлэх тусгай хуудас гаргадаг байв. Тэр хуудсыг Италийн «Gazzetta» хэмээх бутархай мөнгөөр худалдан авдаг байжээ. Яваандадаа уг мэдээллийн хуудас нь түүнийг худалдан авдаг бутархай мөнгө «Gazzetta»-ын нэрээр нэрлэгдэх болсон байна. Тэр нэр Европын зарим орноор тарж, улмаар Орост сониныг «Газета» гэх болжээ.

«

»

Тэгэхээр Европын орнуудад үүссэн сонин гэдэг үгийн язгуур утга нь «сонин юм», «сонин юмыг мэдээлэх» гэхээсээ илүү «Өдөр тутмын», «Өдөр бүр гардаг хэвлэл» гэсэн утга зонхилж байна. Эдгээр оронд сонин гэдэг үгийн утгыг тайлбарлахдаа «Чухал», «Чухал мэдээлэл» гэсэн үгийг нэлээд түгээмэл хэрэглэсэн нь анхаарал татаж байгаа юм.

Дорно дахинь улсууд тухайлбал Хятад оронд сониныг «Bao», «Bao zhi»-«сонин», «Bao kan»-«сонин хэвлэл» гэхчилэн нэрлэдэг. Хятадад «сонин» гэдэг уг өнөөгийн утгаараа үүсч,

түүнийг гаргаж эхэлсэн нь Европ дахинныхнаас үлэмж эрт үед холбогдож байна. Ном, бичгийн эртний түүх, соёлтой энэ орны нутаг дэвсгэр дээр МЭӨ 206-МЭ 220 оны үед оршин тогтнож байсан Хан улсын үед «Ордны сонин» үүссэн тухай мэдээ байдаг. Энэ тухай Хятадын сэтгүүл зүйн түүхч эрдэмтэн Хэ Гүн Жэн «Дундад улсын сэтгүүл зүйн түүх», Английн сэтгүүл зүй судлаач эрдэмтэн Антони Шмис «Дэлхийн сонин сэтгүүлийн түүх» гэдэг номондоо тус тус тэмдэглэсэн боловч, өнөөг хүртэл тэдгээр сонины тухай бодитой баримт олдоогүй байна.

Xарин VII зууны үе буюу 618-907 оны хооронд оршин тогтнож байсан Тан улсын үед хаант төрийн явдлыг өдөр бүр «зурvasлан сийрүүлж гадагш нийтлэн» мэдээлдэг «Бао зуан» хэмээх сонин гарч байсан тухай баттай мэдээ байдаг. Хятад улсын сэтгүүл зүйн түүх судлаач Бүрээчин Дархан уг сонины нэрийн утгыг тайлбарлахдаа «Энэ үгийн «бао» гэдэг нь зарлан нийтлэх, «зуан» нь албан этгээдийн нийтэлсэн бичиг товхимол гэсэн утгатай. «Бао зуан»-д тогтсон нэр хаяг байдаггүй. Ван, гүн зэрэг том язгууртан бол «Бао зуан» гэж, жирийн иргэд бол «Сул сонин», «Зурвааст сонин», «Хуулбар сонин» гэх мэтээр нэрлэдэг байжээ» гэсэн байна. Үүнээс үзвэл «сонин» гэдэг уг Дорно дахинь улсуудад 2200 орчим жилийн өмнө лавтай үүсч, 1400

орчим жилийн өмнөөс бичмэл мэдээллийн нэрийтгэл нэр болж, хэрэглээ нь эрс өссөн байна.

Сонирхол татаж байгаа бас нэг зүйл бол Дорно зүгийн орнууд, тухайлбал Хятад, Япон, Солонгос зэрэг орнуудад сонин гэдэг үгийн язгуур утга болоод бичлэг ойролцоо байгаа явдал мөн. Энэ нь эртний ханзыг гулсуулан хэрэглэсэнтэй холбоотой бололтой. Жишээлбэл Японд сониниг «Shinbun» гэж хэлж, бичих бөгөөд «Шинэ юм», «Шинэ сонин юм сонсох» гэсэн утгатай байдаг бол, Солонгост «Shinmun» гэдэг. Утга нь «Дэлхий ертөнцийн шинэ мэдээг хэлж өгдөг тогтмол хугацаат хэвлэл» гэсэн байдалтай байна. Хятадын «bao», Японы «bun», Солонгосын «tup» гурав ганц нэг авиа ондоosh-соныг эс тооцвол үндсэндээ ойролцоо бичлэг, дуудлагатай байгаа бол, Японы «shin», Солонгосын «shin» хоёрын ханз Япон, Солонгос хоёр авсан нь тодорхой боловч Японы «Shinbun», Солонгосын «Shinmun» хоёрын аль нь анхдагч болох, хэн нь хэнээсээ авсныг баттай хэлэхэд хэцүү. Нэг хэсэг хүн Солонгосчууд Японы эрхшээлд байх үедээ авч хэрэглэсэн байх гэхэд, нөгөө зарим нь Солонгосоос Японд орсон уг гэж үзэх нь ч бий. Миний бodoход эхнийх нь зөв байх бололцоотой. Хамгийн чухал нь Дорно зүгийн орнуудад сонин гэдэг үгэнд «сонин юм», «Шинэ сонин мэдээ» гэсэн утга

зонхилж байгаа явдал мөн. Өрнө, Дорнын хэлэнд сонин гэдэг үг хэрхэн үүссэн хийгээд түүнийг ямар утгаар хэрэглэгдгийг нуршсаны учир бол Монгол хэлний «сонин» гэдэг үгийн гарал, язгуур утгыг тэдгээртэй харьцуулан үзэж, онцлогийг тодлох гэсэнтэй холбоотой юм.

Юуны өмнө хэлэхэд «сонин» гэдэг нь манай төрөлх хэлний “унаган” үг болно. Түүнийг бас ард түмний аман харилцааг эхлүүлдэг түлхүүр үг гэхэд ч эргэлзэх зүйлгүй билээ. Монголын малчин ардууд уулзаж учирсан хэнтэй ч мэнд усаа мэдэлцдэг эртний сайхан заншилтай бөгөөд тэрхүү мэндчилгээний эхэнд «Сонин сайхан юу байна?» хэмээх үг заавал ордог. Мэндчилгээний энэ үг манай ард түмний мэдээллийн эрэлт хэрэгцээнээс үүсч гарсан байж таарна. Малчин ардуудын дунд уламжилсаар ирсэн «Хууч хөөрөх» явдал бол шинэ сонин мэдээ сонсох шаардлахаар буй болсон заншил мөн. Тэд хууч хөөрөхдөө худал ярьдаггүй, заавал бодитой хэрэг явдлын тухай үзсэн буюу сонссон зүйлээ хөөрөлддөг заншилтай. Энэ тухай академич Ц.Дамдинсүрэн бичихдээ «Ойрмог шиг болсон нэгэн явдалд оролцсон буюу үзсэн хүмүүсийн дурсамж, үнэмшмээр аман яриаг ардууд хууч хөөрөх гэдэг бөгөөд бид үүнийг аман өгүүллэг гэж нэрлэж байна» гэсэн байдаг. Сэтгүүл зүйн үүднээс авч үзвэл тэрхүү хууч хөөрөх заншил бол яах аргагүй амаар

солилцдог нийтлэл байжээ. Түүнд нийтлэлд байдаг хэд хэдэн шинж бий. Хууч хөөрөхдөд нэгд: болсон хэрэг явдлыг ярьдаг, хоёрт: тэр хэрэг явдал нь саяхан болсон бөгөөд хуучраагүй байдаг, гуравт: эзэн биегүй юм ярьдаггүй нүдээр үзсэн, оролцсон хэрэг явдлыг ярьдаг, дөрөвт: хэрэв бусдын амнаас сонссон зүйлийг ярих болвол «Тэр ярьсан юм», «Түүнээс сонссон юм» гэхчилэн эх сурвалжийг заавал нэрлэдэг зэрэг нь орчин цагийн мэдээллийн хэрэгслийн зарчимд явцав нийцдэг.

Э

нэхүү «хууч хөөрөх» заншил буюу мэдээлэл солилцохын эхлэлийг мөнөөх «Сонин сайхан юу байна?» гэдэг мэндийн үг тавьж өгдөг. Ялангуяа мэдээллийн зориудын хэрэгсэл үүсээгүй байх үед айл саахалтын хэн нэгнийд хот хүрээ болон хол газраас хүн ирэхэд үдэш оройн цагаар тэр айлд цуглаж элдвийг хөөрөлддөг нь малчин ардын мэдээллийн хэрэгцээг хангах нэг арга болдог байв. Тиймээс ч манай ард түмэн «Айлын ховыг хүүхэд зөөнө, аймгийн ховыг бадарчин зөөнө» гэж цэцлэн хэлэлцдэг билээ.

Академич Х.Сампилдэндэв «Монголчууд уламжлалт заншил ёсоор мэндчилэхдээ «Сонин сайхан юу байна?» гэхэд “тайван сайхан” гэж харилцах буюу нутаг орон, айл гэрийнхний амьдралд тохиолдсон сонин содон зүйлийг ярьж хууч хөөрдөг

байна. Иймд орчин үеийн тогтмол хэвлэлийн нэрийтгэл нэр болсон сонин гэдэг нь монголчуудын уламжлалт мэнчилгээний «Сонин сайхан юу байна?» гэдгийн «сонин» гэдгээс үүдэлтэй мэт» гэсэн нь бидний бодлыг улам ч лавшруулж байгаа юм. Өнөөдөр манайд гарч байгаа бор шар, хариуцлагатай хариуцлагагүй олон хэвлэлийн бичиж байгаа зүйлүүдэд тэрхүү хууч хөөрөх үед хэлэлцдэг зүйл арвин байгаа нь ч сонин гэдэг үг «Сонин сайхан» гэдгээс гаралтайг нотлох нэг үндэс болно.

Тэрхүү «Сонин сайхан» гэдэг үгийн язгуур гарал монголчуудын домгийн сэтгэлгээнээс үүдэлтэй байж болох нэг таамаг байна. Энэ нь Монголын ард түмэн уулзсан газраа харилцан зөрүүлж мэндэлдэг хөөрөгтэй холбоотой таамаг юм. Хөөрөгний хоёр мөрөн дээр байдаг нэгэн амьтны толгойн сийлбэр дүрсийг манай өвөг дээдэс «сонин сайхан» гэж нэрлэх нь бий. Эрт цагт амьтан хүний амгалан тайвныг бусниулсан Сонин сайхан хэмээх айхтар ад зэтгэрийн амьтан гарч ирээд дарагдаж дийлдэхээ болжээ. Түүнийг хэрхэн дарах вэ гэж нэгэн их номтой мэргэн хүнээс асуутал «Тэр ад зэтгэрийн амьтныг илд мэсийн хүчээр бус, харин амны бэлгээр даран сөнөөж болно» хэмээн айлджээ. Тэр цагаас хойш хоёр хүн уулзаад хамгийн түрүүнд «Сонин сайхан байна уу?» гэж нэг нь асуухад нөгөөх нь «нам тайван»,

«тайван амгалан байна» гэх мэтээр амны бэлэгтэй үг хэлдэг болсноор мөнөөх ад зэтгэрийн хорлол аяндаа арилсан гэх домог байдаг. Бас хөөрөгний хоёр мөрөн дээрх тэрхүү амьтны амыг гавласан гинж гэмээр дүрс сийлсэн байдаг нь мөнөөх ад зэтгэрийн амьтны тухай бэлэггүй муу үгсийг тас цоожилж, хэзээ ч хэлэлцэхгүй байхыг андгайлсан утгатай гэдэг. Он цагийн уртад тэрхүү «Сонин сайхан» гэдэг аймшигт амьтныг бус, харин сонсож дуулмаар сонин сайхан мэдээллийг эрэлхийлсэн «Сонин сайхан юу байна?» гэсэн утга болж хувирсан болов уу гэж үзмээр байдаг. Энэ ялдамд тэмдэглэхэд хөөрөг нь монголчуудын мэндлэх ёс занглаас үлэмж хойно гарч ирсэн эд юм. Тиймээс «Сонин сайхан»-ы тухай домгийн сэтгэлгээг хожим хөөрөг хэмээх мэнчилгээний хэрэгсэл үүсэхэд бэлгэдэл дүрс болгож хоёр мөрөн дээр нь сийлсэн байж болно.

Я.Цэвэлийн «Монгол хэлний товч тайлбар толь»-д «Сонин» гэдэг үгийг «1. Тухайн үеийн олон нийт, улс төрийн байдалд зориулсан том хуудастай тогтмол хэвлэл, 2. Хачин жигтэй гайхмаар сонин эдлэл, сонин санаа, сонин яриа, сонин хэрэг, сонин сэвүүн» гэх мэтээр тайлбарласан байдаг. Дээрх тайлбарын хоёр дахь нь «сонин» гэдэг үгийн хэрэглээний (харилцааны) утгыг тайлбарласан бол, эхнийхэд үг үг тухайлсан юмны нэрийтгэл нэр болсны

утыг тайлбарлажээ. Гэвч энэ тайлбар «сонин» гэдэг үгийн гарал хийгээд орчин цагийн хэвлэлийн нэр болсны учрыг тайлбарлахад хангалттай биш юм.

«Сонин сайхан юу байна?» хэмээх энэхүү мэндийн үгийг монголчууд өнгөрсөн зууны эхээр өнөөгийн сонины нэрийтгэл нэр болгосон бололтой байна. Анх 1895 онд Чита хотод гарч эхэлсэн «Дорнод хязгаарын амьдрал» хэмээх сонины эхэнд уг сонины зорилго чиглэлийг тодорхойлж бичихдээ «Утга мэдэхүйеэ хялбар ба тариалан хийгээд мал тэргүүтний ажил болон худалдаа ба олзын үйлдвэр хийгээд

ном бичиг зохиохуй ухаан ба уран аргын үүднээс аж төрлийн хэрэгслийг хямгатай зарах ёсны орос ба монгол, буриад хэлээр гарсан “Орос, дорно зах хязгаарын аж төрөл” хэмээгдэх сонинт бичиг болой» гэсэн нь тогтмол хэвлэл “сонин юм” бичдэг гэсэн санааг анх түрүүнд гаргаж тавьсан хэрэг юм. 1915 онд эхэлж гарсан «Нийслэл хүрээний сонин бичиг»-т ч бас сонин гэдэг үгийг хэрэглэсэн нь үүний тодорхой жишээ мөн. Мөн 1909 оноос Харбинд монгол хэлээр гарч байсан «Монголын сонин

бичиг» ч гэсэн сонин хууч яриаг сонин бичиг болгож орчилжуулсны гэрч болдог. Эдгээрээс дүгнэлт хийж үзэхэд монголчууд анх тогтмол хэвлэл гаргахдаа «сонин сайхан» гэдэг уугуул үгийнхээ утыг залган авч «сонин юмын тухай бичиг» гэсэн утгаар хэрэглэсэн байна. Тиймээс ч манай ууган хэвлэлүүдэд «Сонин бол өглөө босоод нүүрээ хардаг тольтой адил», «Сонин уншдаг хүн үүдээрээ гараагүй байж ертөнцийн сониниг хэнхдэг дотроо агуулна» гэхчилэн бичиж байв.

«

1915 онд эхэлж гарсан «Нийслэл хүрээний сонин бичиг»-т ч бас сонин гэдэг үгийг хэрэглэжээ. Мөн 1909 оноос Харбинд монгол хэлээр гарч байсан «Монголын сонин бичиг» ч гэсэн сонин хууч яриаг сонин бичиг болгож орчилжуулсны гэрч болдог. Эдгээрээс дүгнэхэд монголчууд анх тогтмол хэвлэл гаргахдаа «сонин сайхан» гэдэг уугуул үгийнхээ утыг залган авч «сонин юмын тухай бичиг» гэсэн утгаар хэрэглэсэн байна.

»

ёстой гэсэн бодомж гарч ирнэ. Тэрхүү сонин сайхан юм нь хэнд ч хэрэггүй ховжив, хараал зүхэл биш, харин хэрэгтэй мэдлэг, мэдээлэл, амьдрал ахуйд аваад хэрэглэчих ашигтай зүйл байгаасай гэсэн хүсэл эрмэлзэл нь сонин гаргах анхдагч шалтгаан байсан байх. Үүнээс үүдээд манай өнөөгийн тогтмол хэвлэлийн нийтлэлд чухам сонин сайхан юмын эзлэх хувь хэмжээ хэдий хэр байгааг ч бодож үзүүштэй санагддаг.

Хууч ярианд тухайн харилцаж байгаа хүмүүсийн сонирхол, мэдлэгийн

цараанаас хамаараад ярих зүйлийн сэдэв, хүрээ янз янз байв. Нүүдэлч малчин эрс хөдөө хээр, зам зуур, эсвэл уул овоон дээр уулзахдаа хот хүрээний сонин хачин, морь мал, гаанс хөөрөгний чанар чансаа, үнэ цэнгийн тухай, түүгээр ч зогсохгүй цаг төрийн байдал, улс гүрний хэрэг явдлыг хэлэлцдэг нь өнөөгийн хэвлэлд бичдэг улс төр, эдийн засгийн тойм, хөрөнгийн биржийн мэдээлэл байжээ хэмээн үзэж болно. Түүнчлэн монгол эмэгтэйчүүдийн хэн нэг нь хийцтэй шаргал цайгаа хот айлынхаа авгайтай хувааж уунгаа эр нехэр, үр хүүхдийнхээ тухай, тэдэндээ зориулан оёж шидэж байгаа үйл үртсийнхээ тухай, тэр ч бүү хэл өвгөнийг эзгүй хойгуур тэдний нэг хар юм тэгж, ингэж татаж чангаагаад гэхчилэн элдвийг хөөрөлддөг. Тэр нь өнөөгийн шар хэвлэлүүдийн бичлэг, ялангуяа «жиг жуг» мэтийн булагтуудад гардаг элдэв дэл сул мэдээ чимээтэй адил юм.

Гэтэл үүнээс үүдээд бодох юм бидэнд зайлшгүй гарч ирнэ. Нэгд: сонин гэдэг үг урьдынх шиг дэл сул юм ярихын нэр байхаа нэгэnt болж үнэн бодитой, оюунлаг мэдээллийн утга болж өөрчлөгдсөн, хоёрт: сонин хэвлэлд бичдэг зүйл бол дэний нэг сул задгай яриа биш, харин ихээхэн нарийн бүтэц зохиомжтой утга зохиолын нэг хэлбэр болсныг эрхбиш бодолцох цаг болсон байна. Энэхүү жижиг өгүүллийн материалыг цуглуулах явцад

дараах санал, дүгнэлт гарч байна.
Үүнд:

1. «Сонин» гэдэг үгийг монголчууд тогтмол хэвлэлд оноож өгөхдөө бусдаас дамжуулж аваагүй, тэр тусмаа «Газета», «Newspaper», «Journal», «Zeitung», «Bao kan», «Shinbun», «Shinmun» зэрэг үгийн алины ч орчуулга биш, харин уламжлалт мэндчилгээний «Сонин сайхан юу байна?» гэдэг үгийг шинэ утгаар идээшүүлэн хэрэглэсэн ажээ.

2 ■

Тэрхүү «Сонин сайхан юу байна?» гэдэг мэндчилгээний үг нь монголчуудын домгийн сэтгэлгээнээс, тухайлбал амны бэлэггүй үг хэлэлцэхгүй байх ариун нандин заншилаас үүдэлтэй хэмээн үзэж болмоор байна.

3. «Сонин» гэдэг үг Өрнө дахинд «Өдөр бүрийн» гэсэн утгаар анх үүссэн бөгөөд чухал шаардлагатай мэдээллийг өдөр бүр түгээж байдаг хэвлэлийн бүтээгдэхүүний нэр болж төлөвшен байна.

4. Дорно дахины улс үндэстнүүдийн бичиг соёлд «Сонин мэдээ», «Шинэ сонин юм» гэсэн утгаараа түлхүү хэрэглэгдэж иржээ.

5. Өрнөдийн орнуудад тогтмол хэвлэлийн нэг төрөл болох сониниг анх үүсгэхдээ сонгодог латин хэлний «Diurnus»-аас гаралтай «Journal» гэдэг үгээр тэмдэглэж байгаад хожим сэтгүүлийн нэр болгож хэвшүүлсэн байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Бүрээчин дархан. Дундад улсын сэтгүүл зүйн түүхэн тойм. Хөхтөн.
2. Дамдинсүрэн Ц. 1987. Монголын уран зохиолын өв уламжлалын асуудлууд. УБ.
3. Норовсүрэн Л. 1996. Редакторлах зүйн онол, дадлага. УБ.
4. Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ.
5. Норовсүрэн Л. 2005. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.
6. Рашир. 1979. Хорин нэгт тайлбар толь. Хөхтөн.
7. Сагансэцэн. 1984. Эрдэнийн товч. Хөхтөн.
8. Самилдэндээв Х. 2000. Нэг ходоод, хоёр толгойтой шувууны үлгэр. УБ.
9. Төгсбаяр. 1998. Чингис хааны домгууд. Хөхтөн.
10. Төгсцогт. 1999. Монгол сонин сэтгүүлийн түүхэн тойм. Хөхтөн.
11. 1994. Хорин наймт тайлбар толь. Хөхтөн.
12. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.
13. Шагж. 1998. Эрэхүйеэ хялбар болгосон монгол үгний тайлбар - Чандманийн эрих. Бээжин.

14. Shinhett. 2004. "Сэтгүүл" гэдэг үгийн учир. Монгол хэлбичиг. Хөхтөн. №4.
15. Bloch O., Wartburg W. von. 1932. Dictionnaire étymologique de la langue française. Paris.
16. 2002. Langenscheidts Grosswoerterbuch Deutsch als Fremdsprache. Berlin und Muenchen.
17. Lessing D. 1960. Mongolian English Dictionary. California.
18. Robert P. 1988. Dictionnaire de la langue française. Paris.
19. 2000. The American heritage dictionary of the English language. Boston, New York.

Resume

The semantic meaning of "Sonin" world

In this article, it promulgated that a word, which is called as "Sonin" with a meaning of "news", is originated from "Sonin saikhan yu bna?" – "How are you?" by comparing with other nations' meanings of the above-mentioned word "sonin". This word is not borrowed from a foreign language but it is a greeting word of fundamental Mongolian language and accordingly, we reached to a conclusion that the word expresses nomads' inspiration to find out news.